АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

Эрдэнэбулган сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: АРА-2024/46-НА-СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.open.audit.mn

Архангай аймаг

2024 он

Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас:7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:

Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит ХХК

Утас:  99197346, 88114867 Цахим хаяг: Shinjlenmagadlahui. audit@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2024.02.25 № 106

танай ______-ны №______-т

ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 2 ДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Н.ГЭРЭЛЧУЛУУН ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэбулган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Эрдэнэбулган сумын Ерөнхий боловсролын 2-р сургууль нь тайлант онд БШУЯ-наас ирүүлсэн 16,787.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг төлбөргүй хүлээн авсныг санхүүгийн тайланд тусгасан байна.

### Аудитын гол асуудал

“Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын дагуу тус байгууллагын албан хаагчдын үндсэн цалинг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс шинэчлэн баталсан. Үүнтэй холбоотойгоор цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 25 хувиар өссөн байна.

Боловсрол, шинжлэх ухааны яам, Боловсролын үнэлгээний төвөөс багшийн болон байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр 1 дүгээр түвшинд үнэлэгджээ.

### Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 үндсэн зорилтын хүрээнд 141 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн БШУГ-аас 100 хувьтай үнэлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Данс | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| I | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 135,859,645.59 | 277,594,180.86 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 28,562,346.00 | 164,197,841.39 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 28,562,346.00 | 164,197,841.39 |
| 3121 | Төгрөг | 28,562,346.00 | 164,197,841.39 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 28,562,346.00 | 164,197,841.39 |
| 33 | АВЛАГА | 9,257.52 | 2,908,500.00 |
| 331 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 9,257.52 | 2,908,500.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 107,288,042.07 | 110,487,839.47 |
| 351 | Түүхий эд материал | 4,956,898.10 | 4,956,898.10 |
| 3513 | Эм боох материал | 4,956,898.10 | 4,956,898.10 |
| 354 | Хангамжийн материал | 102,331,143.97 | 105,530,941.37 |
| 3542 | Аж ахуйн материал | 66,111,921.07 | 66,111,921.07 |
| 3545 | Барилгын засварын материал | 2,239,000.00 | 2,239,000.00 |
| 3547 | Бусад хангамжийн материал | 33,980,222.90 | 37,180,020.30 |
| II | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 9,195,090,901.35 | 8,985,435,046.39 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 9,195,090,901.35 | 8,985,435,046.39 |
| 392 | Биет хөрөнгө | 9,051,148,401.35 | 8,841,740,046.39 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 8,807,299,682.90 | 8,807,299,682.90 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -294,552,172.56 | -441,340,500.60 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 486,487,492.81 | 483,929,609.90 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -245,810,893.06 | -285,040,113.49 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 386,402,602.04 | 394,510,519.94 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -133,597,265.28 | -167,391,960.76 |
| 39217 | Ном | 44,918,954.50 | 49,772,808.50 |
| 393 | Биет бус хөрөнгө | 143,942,500.00 | 143,695,000.00 |
| 39301 | Програм хангамж | 2,087,500.00 | 2,087,500.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,345,000.00 | -1,592,500.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 143,200,000.00 | 143,200,000.00 |
| III | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 9,330,950,546.94 | 9,263,029,227.25 |
| IV | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 12,092,881.00 | - |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 12,092,881.00 | - |
| 413 | Өглөг | 12,092,881.00 | - |
| 4131 | Ажилчидтай холбогдсон өглөг | 4,645,981.00 | - |
| 4136 | Бусад өглөг | 7,446,900.00 | - |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 7,446,900.00 | - |
| V | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 9,318,857,665.94 | 9,263,029,227.25 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 9,318,857,665.94 | 9,263,029,227.25 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,053,599,483.20 | 1,053,599,483.20 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,053,599,483.20 | 1,053,599,483.20 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 8,265,253,754.71 | 8,209,425,316.02 |
| 5121 | Өмнөх үеийн үр дүн | 8,265,253,754.71 | 8,265,253,754.71 |
| 5122 | Тайлант үеийн үр дүн | | -55,828,438.69 |
| 513 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 4,428.03 | 4,428.03 |
| VI | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 9,330,950,546.94 | 9,263,029,227.25 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 12,407,473,247.73 | 3,713,064,751.40 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 11,881,592,247.73 | 27,973,451.40 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 9,390,828,547.73 | 27,973,451.40 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 9,390,828,547.73 | 175,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 7,446,900.00 | |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,175,000.00 | |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 9,378,206,647.73 | |
| 120005 | Түрээсийн орлого | | 7,810,800.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | | 16,787,854.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | | 3,199,797.40 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 2,490,763,700.00 | |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 2,490,763,700.00 | |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 525,881,000.00 | 3,685,091,300.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | | 3,233,687,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 3,233,687,100.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 5,000,000.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,000,000.00 | |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 520,881,000.00 | 451,404,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 520,881,000.00 | 451,404,200.00 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 3,088,615,581.79 | 3,672,676,436.35 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,088,615,581.79 | 3,672,676,436.35 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,826,639,457.57 | 3,610,825,836.35 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,857,275,251.00 | 2,307,788,012.33 |
| 210101 | Үндсэн цалин | 1,375,231,926.00 | 1,542,976,108.12 |
| 210102 | Нэмэгдэл | 363,873,263.00 | 635,925,342.12 |
| 210104 | Урамшуулал | 118,170,062.00 | 128,886,562.09 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 230,038,094.26 | 289,566,599.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 156,463,522.53 | 196,905,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 18,408,573.63 | 23,164,999.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 14,726,898.88 | 18,532,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,676,245.40 | 4,632,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 36,762,853.82 | 46,330,900.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 419,277,608.00 | 433,284,200.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 19,385,218.00 | 26,587,907.01 |
| 210302 | Түлш, халаалт | 394,112,681.00 | 394,160,747.46 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,779,709.00 | 12,535,545.53 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 3,180,000.00 | 38,691,125.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 29,799,625.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,180,000.00 | 2,830,000.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | 6,061,500.00 |
| 2105 | Нормативт зардал | | 213,508,520.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 263,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | | 213,245,520.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 28,978,500.00 | 23,618,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 28,978,500.00 | 23,618,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,304,147.00 | 28,467,974.80 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 15,983,150.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,304,147.00 | 12,484,824.80 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 284,585,857.31 | 275,901,405.22 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 38,546,950.00 | 36,071,850.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 25,695,580.00 | 290,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 220,343,327.31 | 239,539,555.22 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 261,976,124.22 | 61,850,600.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 252,226,010.00 | 61,850,600.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 203,470,710.00 | 9,775,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 48,755,300.00 | 52,075,600.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 9,750,114.22 | |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,750,114.22 | |
| | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | |
| | Дотоод эх үүсвэрээр | | |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 9,318,857,665.94 | 40,388,315.05 |
| 145 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | | |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | | 96,216,753.74 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | | 96,216,753.74 |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | | -96,216,753.74 |
| V | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 9,318,857,665.94 | -55,828,438.69 |
| | | | |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 3,029,266,600.00 | 3,693,077,100.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 12,621,900.00 | 7,985,800.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 12,621,900.00 | 7,985,800.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 12,621,900.00 | 175,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 7,446,900.00 | |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,175,000.00 | |
| 120005 | Түрээсийн орлого | | 7,810,800.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 3,016,644,700.00 | 3,685,091,300.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 2,490,763,700.00 | 3,233,687,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,490,763,700.00 | 3,233,687,100.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 5,000,000.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,000,000.00 | |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 520,881,000.00 | 451,404,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 520,881,000.00 | 451,404,200.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | | |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 2,875,004,241.00 | 3,448,129,004.61 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,875,004,241.00 | 3,448,129,004.61 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,613,028,116.78 | 3,174,138,484.61 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,852,629,270.00 | 2,315,333,235.81 |
| 210101 | Үндсэн цалин | 1,370,585,945.00 | 1,550,527,794.60 |
| 210102 | Нэмэгдэл | 363,873,263.00 | 635,918,879.12 |

| | | | |
|---|---|---|---|
| 210104 | Урамшуулал | 118,170,062.00 | 128,886,562.09 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 230,047,351.78 | 289,566,599.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 156,472,780.05 | 196,905,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 18,408,573.63 | 23,164,999.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 14,726,898.88 | 18,532,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,676,245.40 | 4,632,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 36,762,853.82 | 46,330,900.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 419,277,608.00 | 433,284,200.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 19,385,218.00 | 26,587,907.01 |
| 210302 | Түлш, халаалт | 394,112,681.00 | 394,160,747.46 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,779,709.00 | 12,535,545.53 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | |
| 2105 | Нормативт зардал | | |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 22,096,000.00 | 18,120,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 22,096,000.00 | 18,120,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,956,657.00 | 33,435,299.80 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 15,246,200.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,956,657.00 | 18,189,099.80 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 84,021,230.00 | 84,399,150.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 51,083,130.00 | 54,355,550.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 32,938,100.00 | 30,043,600.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 261,976,124.22 | 273,990,520.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 252,226,010.00 | 273,990,520.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 203,470,710.00 | 221,914,920.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 48,755,300.00 | 52,075,600.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 9,750,114.22 | |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,750,114.22 | |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 154,262,359.00 | 244,948,095.39 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | | 109,312,600.00 |
| 22 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авах | | 109,312,600.00 |
| | Дотоод эх үүсвэрээр | | 109,312,600.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | | 109,312,600.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | | -109,312,600.00 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 154,262,359.00 | 135,635,495.39 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 28,562,346.00 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 164,197,841.39 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

| Д/Д | Үзүүлэлт | Засгийн газрын сан | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | ЗГ-н хувь оролцооны дүн |
|---|---|---|---|---|---|
| 10 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,053,599,483.20 | 4,428.03 | 8,265,253,754.71 | 9,318,857,665.94 |
| 17 | Тайлант үеийн үр дүн | | | -55,828,438.69 | -55,828,438.69 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 19 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,053,599,483.20 | 4,428.03 | 8,209,425,316.02 | 9,263,029,227.25 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн |
|---|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 3,721,464,500.00 | 3,557,441,604.61 | 164,022,895.39 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,721,464,500.00 | 3,448,129,004.61 | 273,335,495.39 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,404,456,000.00 | 3,174,138,484.61 | 230,317,515.39 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,422,792,300.00 | 2,315,333,235.81 | 107,459,064.19 |
| 210101 | Үндсэн цалин | 1,650,178,200.00 | 1,550,527,794.60 | 99,650,405.40 |
| 210102 | Нэмэгдэл | 641,869,300.00 | 635,918,879.12 | 5,950,420.88 |
| 210104 | Урамшуулал | 130,744,800.00 | 128,886,562.09 | 1,858,237.91 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 302,848,600.00 | 289,566,599.00 | 13,282,001.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 205,936,900.00 | 196,905,600.00 | 9,031,300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 24,227,900.00 | 23,164,999.00 | 1,062,901.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 19,382,300.00 | 18,532,300.00 | 850,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,845,600.00 | 4,632,800.00 | 212,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 48,455,900.00 | 46,330,900.00 | 2,125,000.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 433,284,200.00 | 433,284,200.00 | 0.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 26,588,000.00 | 26,587,907.01 | 92.99 |
| 210302 | Түлш, халаалт | 394,112,700.00 | 394,160,747.46 | -48,047.46 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 12,583,500.00 | 12,535,545.53 | 47,954.47 |
| 210604 | Урсгал засвар | 18,120,000.00 | 18,120,000.00 | 0.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 35,286,800.00 | 33,435,299.80 | 1,851,500.20 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 15,257,700.00 | 15,246,200.00 | 11,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 20,029,100.00 | 18,189,099.80 | 1,840,000.20 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 192,124,100.00 | 84,399,150.00 | 107,724,950.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 162,080,500.00 | 54,355,550.00 | 107,724,950.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 30,043,600.00 | 30,043,600.00 | 0.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 317,008,500.00 | 273,990,520.00 | 43,017,980.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 317,008,500.00 | 273,990,520.00 | 43,017,980.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 264,932,900.00 | 221,914,920.00 | 43,017,980.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 52,075,600.00 | 52,075,600.00 | 0.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | 109,312,600.00 | -109,312,600.00 |
| | Дотоод эх үүсвэрээр | | 109,312,600.00 | -109,312,600.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | | 109,312,600.00 | -109,312,600.00 |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 3,721,464,500.00 | 3,693,077,100.00 | 28,387,400.00 |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 3,233,687,100.00 | 3,233,687,100.00 | 0.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 3,233,687,100.00 | 3,233,687,100.00 | 0.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 451,404,200.00 | 451,404,200.00 | 0.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 451,404,200.00 | 451,404,200.00 | 0.00 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 36,373,200.00 | 7,985,800.00 | 28,387,400.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 7,810,800.00 | 7,985,800.00 | -175,000.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 28,562,400.00 | | 28,562,400.00 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 28,562,346.00 | -28,562,346.00 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 164,197,841.39 | -164,197,841.39 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | 0.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | 0.00 |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 130 | 130 | 0.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 4 | 4 | 0.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 96 | 96 | 0.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 30 | 30 | 0.00 |
| 63 | СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР) | 1800 | 2015 | -215.00 |
| 630 | ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД | 1800 | 2015 | -215.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулагдаагүй 2 зөрчилтэй асуудлаас материаллаг алдааны зөрчил нь 3,619.7 мянган төгрөг бөгөөд тогтоосон материаллаг байдлын дүн 26,050.3 мянган төгрөгөөс бага байгаа тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

### 3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг харуулав. Үүнд:

3.1.1 Зардлын данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Мэдээлэл технологийн зардлаас 3619.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ий өдрийн 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ийн "мэдээлэл технологийн үйлчилгээ зардлын ангилалд компьютерын хэрэглээний программуудын эрхийн төлбөр, лицензийн төлбөр, тэдгээрийн засвар үйлчилгээг гуравдагч этгээдээс худалдан авах төлбөр энд хамаарна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

<u>*Шийдвэрлэсэн нь*</u>: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2024 оны 03 дугаар сарын 22-ны дотор ирүүлнэ үү.

*Зөвлөмжийн биелэлтийг тооцож, нотлох баримтыг хангуулан 2024 оны 06 дугаар сарын 20-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.*

3.1.2 Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу, нярвын тайлан иж бүрэн бус хангалтгүй байна.

Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” 13.6 “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь*: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2024 оны 03 дугаар сарын 22-ны дотор ирүүлнэ үү.

*Зөвлөмжийн биелэлтийг тооцож, нотлох баримтыг хангуулан 2024 оны 06 дугаар сарын 20-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.*

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

---

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Төсөвт зохицуулалт хийхгүй зарцуулсан | 1 | 3,619.7 | | | | | 1 | 3,619.7 | | | | |
| Анхан шатны баримтын иж бүрдэл хангалтгүй | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| **Дүн** | **2** | **3,619.7** | | | | | **2** | **3,619.7** | | | | |